| 6 | Борооны ус ашиглах | Ногоон байгууламжид борооны усыг ашиглан усалгаажуулах | Усны нөөцийг хэмнэж ногоон байгууламж услах | Жилдээ | • Дээврийн ус буюу борооны усыг 200 литрийн усны саванд цуглуулан ногоон байгууламжийг усалдаг. Баримтыг 2.2.3 дугаар хэсгээс харна уу. |
| 7 | Үйлдвэрээс бохир ус гарах | Бага оврын цэвэрлэх байгууламжийн шинэчлэл, сайжруулалтыг хийх | Бага оврын цэвэрлэх байгууламжийн шинэчлэл, сайжруулалтыг хийх | Жилдээ | • Үйлдвэрийн бага оврын ариун цэврийн байгууламжийн дотор тал нь бетон кольцо бүхий хийцлэлтэй тул бохир усыг цаг тухайд нь гэрээний дагуу татан зайлуулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. |
| 8 | Хаягдал бохир усны орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл | Цэгийг бетон, төмөр бетон болон бусад ус үл нэвчих материалаар доторлоно | Цэгийг бетон, төмөр бетон болон бусад ус үл нэвчих материалаар доторлогоо хийх талаар судлах, үнийн санал авах | Жилдээ | • Үйлдвэрийн бага оврын ариун цэврийн байгууламжийн дотор тал нь бетон кольцо бүхий хийцлэлтэй тул бохир усыг цаг тухайд нь гэрээний дагуу татан зайлуулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. |
| 9 | | Цэгийн хөрсний устай харьцах хэсгийг ус үл нэвчих материалаар хийнэ. | Цэгийн хөрсний устай харьцах хэсгийг ус үл нэвчих материалаар хийх талаар судлах үнийн санал авах | Жилдээ | • Үйлдвэрийн бага оврын ариун цэврийн байгууламжийн дотор тал нь бетон кольцо бүхий хийцлэлтэй тул бохир усыг цаг тухайд нь гэрээний дагуу татан зайлуулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 10 | | Ус ашиглагч нь цэгийн эзлэхүүний 70-80 хувь дүүрсэн үед суллах | Бохир усыг зөөвөрлөж зайлуулах, орчны ариун цэврийг хангах | Жилдээ | • “Чандмань-Налайх” ОНӨААТҮГ-тай 2025.02.11-ны өдөр байгуулсан “Аж ахуйн нэгж байгууллагын бохир усыг нийлүүлэх” гэрээний дагуу бохир усыг татан зайлуулж байна. |
| 11 | | Цэг болон цэгийн орчинд халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээр халдваргүйжүүлэлтийг хийлгэх гэрээ байгуулах | Бохир усны орчны ариун цэврийг хангах | | • Компаниас 2025.02.07-ны өдөр “Маргад Эрдэнэ-Уул”ХХК-тай байгуулсан гэрээний дагуу уг ажлыг хийж гүйцэтгэж байна. |

### ➢ 2.2.1. Усыг зохистой хэрэглэхэд хяналт тавих

Гүний худгаас хангах ажилчдын цайны газрын усны оролт дээр тоолуур суурьлуулж баталгаажуулсан.




СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ

№ ЭУ ..........147854

..........НД 3х-НММ Үйлдвэр..........-д

(хэрэглэгчийн нэр)

ашиглаж байгаа ..........LXSG-20.... загварын ..........2.5.......... м³/ц

хэмжих хязгаартай, ...20.... мм-ийн голчтой № ..........201801055.......... -ын

халуун, хүйтэн усны тоолуурыг №..........015.......... лацаар битүүмжилж

(доогуур зурах)

..........2026....оны ..........04....... -р сарын ..........19..... -ны өдөр хүртэл улсын баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: ..........03845..........м³

Лабораторийн тэмдэг

Улсын шалгагчийн гарын үсэг, тэмдэг

2024... оны .....04-р сарын ..19... -ны өдөр

Үйлдвэрийн дотоод хэрэглээг хянах зориулалттай тоолууржуулсан байдал

Дэлхий нийтээрээ жил бүрийн 3 сарын 22-нд “Усны өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлдэг бөгөөд энэ жил дэлхий нийтээр “Мөстөл, мөсөн голыг хамгаалах нь” уриан дор тэмдэглэн өнгөрүүлсэн.

Удирдамжийн дагуу 2025.05.02-ны өдөр Налайх дүүрэгт байрлах Үйлдвэрийн байран дээр ажиллаж байгаа ажилтнуудыг хамруулан “Мөстөл, мөсөн голыг хамгаалах нь” сэдвээр нийт ажилчдад сургалт орон тус сэдэвтэй холбоотой асуулт хариулт бэлдэн ажилчдын дунд хөгжөөн цэнгээнт “АХА” тэмцээн зохион байгуулж эхний 3 байрт шалгарсан ажилчдад өргөмжлөл гарын бэлгээр шагнаж урамшуулсан. Тус сургалтанд Үйлдвэрийн 31, Захиргаа, хүний нөөцийн албаны 6, Инженер техникийн албаны 3, Маркетингийн албаны 2, Чанарын албаны 1, Хангамжийн албаны 1, Санхүүгийн албаны 3, нийт 47 ажилтан хамрагдсан.




Сургалтын сэдэв



АХА тэмцээний шагнал

|  |  |
|---|---|
| Дэлхийн усны өдрийн удирдамж | АХА тэмцээний асуулт |

**Document 1 (left):**

БАТЛАВ:
"НЭЙШНЛ МАЙНИНГ МАШИНЕРИ" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
.......................... Ш.ХИШИГБАТ
2025 оны 05 сарын 01-ний өдөр

"ДЭЛХИЙН УСНЫ ӨДӨР"-ИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ

**НЭГ. ЗОРИЛГО**

Дэлхий нийтээрээ жил бүрийн 3 сарын 22-нд "Усны өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай бөгөөд энэ жил "Мөстөл, мөсөн голыг хамгаалах нь" уриан дор сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан мөсөн голууд хурдацтай хайлж байгаагаас урьдчилан сэргийлэх, таниулахад оршино.

**ХОЁР: ХУГАЦАА, ХАМРАХ ХҮРЭЭ**

Дэлхийн усны өдрийг тохиолдуулан зохион байгуулж буй арга хэмжээг компанийн нийт ажилтны хүрээнд 2025 оны 05-р сарын 02 -ний өдрийн 15:00 цагт сургалтын танхимд зохион байгуулна.

**ГУРАВ: ҮЙЛ АЖИЛЛАГАА**

1. "Усны зохистой хэрэглээ" сэдэвт сургалт
2. "Мөстөл, мөсөн голыг хамгаалах нь" сэдэвт сургалт
3. "Дэлхийн усны өдөр" сэдэвт "Асуулт Хариулт Асуулт" /АХА/ тэмцээн

**ДӨРӨВ: ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ**

АХА тэмцээний эхний 3 байрыг шалгаруулна.

1-р байр Өргөмжлөл, гарын бэлэг

2-р байр Өргөмжлөл, гарын бэлэг

3-р байр Өргөмжлөл, гарын бэлэг

БОЛОВСРУУЛСАН:
ХАБЭАБО ХАРИУЦСАН ИНЖЕНЕР Ч.БЯМБАБАТ

**Document 2 (right):**

NMM "Нэйшнл майнинг машинери" ХХК

АХА

2025 оны 05 дугаар сарын 02

1. Дэлхийн усны өдөр хэзээ болдог вэ? /3.22/
2. Дэлхийн усны өдрийг хэзээнээс тэмдэглэж эхэлсэн бэ? /1993 оноос/
3. Биеийн энергийн гол эх үүсвэр юу вэ? /Нүүрс ус/
4. Насанд хүрсэн хүн өдөрт хэдэн цаг унтах ёстой вэ? /7-9/
5. хүн төрөлхтөн химийн аргаар гаргаж авч чадаагүй цорын ганц бүтээгдэхүүн юу вэ? УС
6. Аюулыг мэдээлэх нь хэний үүрэг вэ? /Байгууллагын бүх ажилтнууд/
7. Нарны гэрэлд ямар аминдэм үүсдэг вэ? /Д витамин/
8. Ямар эрхтэн цусыг бүх биед шахдаг вэ? /зүрх/
9. Хүний биеийн хамгийн том эрхтэн юу вэ? /арьс/
10. Өнөөдөр дэлхий дээр хэдэн тэрбум хүн ундны усаар гачигдаж байгаа вэ? 1,7
11. 2025 онд өмнөх тоо хэдэн тэрбум болж нэмэгдэх магадлалтай вэ? 3
12. Бие махбодийг халдвараас хамгаалах үндсэн хамгаалалт юу вэ? /Дархлааны систем/
13. Анхны тусламж үзүүлэх ач холбогдол нь юу вэ? /хүний амь насыг аварна/
14. Гал түймэр гарах шалтгаан буюу галын гурвалжинг нэрлэнэ үү? /агаар, дулаан, шатах зүйл/
15. Дархлааны системийг сэргээхийн тулд юу хийх шаардлагатай вэ? /Унтах/
16. Дэлхийн хэдэн хувийг ус эзэлдэг вэ? /71%/
17. МУ-н төв цэг? /Өвөрхангай аймаг/
18. МУ газар нутгийн хэмжээгээр дэлхийд хэддүгээрт ордог вэ? /18/
19. Огт агааргүй орчинг ямар орчин гэдэг вэ? /Вакум/
20. Биеийн эд эсийг бий болгож, нөхөн сэргээхэд ямар шим тэжээл тусалдаг вэ? /уураг/
21. Хүний биеийн гол мэдрэхүйн эрхтэн юу вэ? /Арьс/
22. Хүн өдөрт дунджаар хэдэн литр ус уух шаардлагатай вэ? /2-3 литр/
23. Дэлхийн гадаргы хэдэн хувь нь усаар бүрхэгдсэн байдаг вэ? /Ойролцоогоор 71%/
24. Африк болон Азид ус авахын тулд эмэгтэйчүүд дунджаар хэдэн км газрыг туулдаг вэ? 6 км
25. Хордлого тайлах гол эрхтэн юу вэ? /Элэг/
26. Биеийн яс, шүдний үндсэн бүрэлдэхүүн хэсэг юу вэ? /Кальци/
27. ХАБЭА-н тухай хуулинд ажилтан хэдэн эрх, хэдэн үүрэг заагдсан байдаг вэ? /5 эрх, 8 үүрэг/
28. 2-с дээш өдрийн чөлөөг хэний зөвшөөрлөөр олгодог вэ? /Гүйцэтгэх захирал/
29. Зүг чигийг олдог багаж? /Луужин/
30. Цахилгаан гүйдлийг хэмжих нэгж? /Ампер/
31. Нар дэлхийгээс ямар зайтай оршдог вэ? /150 сая км/
32. Шим тэжээл, хог хаягдлыг зөөвөрлөх биеийн гол шингэн юу вэ? /Цус/
33. Бие махбодид энерги хуримтлуулах гол тэжээл юу вэ? /Өөх/
34. Хоол боловсруулахад тусалдаг ургамал юу вэ? /Цагаан гаа/

Зураг №8. Удирдамж, сургалтын явц, аха тэмцээн зохион байгуулсан байдал

➢ **2.2.3 Усны төлбөр төлөх, хаягдал усанд хяналт шинжилгээ хийлгэх**

|  |  |
|---|---|

**Document 3 (left):**

ХАСБАНК — ЦАХИМ ГҮЙЛГЭЭНИЙ БАРИМТ

ШИЛЖҮҮЛЭГЧИЙН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

| | |
|---|---|
| Банкны нэр: | ХасБанк |
| Данс: | 5002767309 |
| Нэр: | НЭЙШНЛ МАЙНИНГ МАШИНЕРИ ХХК |
| Дүн: | 142,880.00 |
| Валют: | MNT |

ХҮЛЭЭН АВАГЧИЙН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

| | |
|---|---|
| Банкны нэр: | ХасБанк |
| Нэхэмжлэхийн №: | 3241200854476 |
| Нэр: | ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР |
| Дүн: | 142,880.00 |
| Валют: | MNT |

ГҮЙЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

Гүйлгээний дугаар: **XB0080774**

Гүйлгээний утга: **3241200854476, Нэйшнл майнинг машинери, 88880024, НЭЙШНЛ МАЙНИНГ МАШИНЕРИ ХХК**

Гүйлгээний шимтгэл: **-**

Гүйлгээний хүсэлт илгээсэн: **nmm1** Гүйлгээ баталсан: **nmm3**

Гүйлгээ хийсэн огноо: **2024-12-10**

*Энэхүү цахим гүйлгээний баримтыг засварлах,Мэдээлэл өөрчлөх болон аливаа хууль бус зорилгоор ашиглахыг хориглоно.*

**Document 4 (right):**

НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗАР
Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 4 дүгээр хороо, Арцатын ам, Наадамчдын гудамж, 1200 тоот. Утас 11-318551

MNAS Accreditation system TL 176

УСАН ХАЛААЛТЫН ЗУУХНЫ ХЭМЖИЛТИЙН ДҮНГИЙН ХУУДАС
УХЗ 25/43

**Бичиг ирсэн огноо:** 2025.10.01

**Эзэмшигчийн нэр:** "Нэйшнл Майнинг Машинери" ХХК

**Түлшний төрөл:** Мидлинг

**Хэмжилт хийсэн газрын нэр, хаяг:** Налайх дүүрэг 32-р хороо

**Хэмжилт хийсэн зуухны марк, хүчин чадал:** DZL 4тн/цаг

**Шинжилгээний хийсэн өдөр:** 2025.10.13

**Шинжилгээний хариу гарсан огноо:** 2025.10.28

**Шинжилгээний хариу:** Тэнцсэн

| Үзүүлэлт | NOx мг/нм$^3$ | $SO_2$ мг/нм$^3$ | CO мг/нм$^3$ | TSP мг/нм$^3$ |
|---|---|---|---|---|
| Хэмжилтийн үр дүн | 32 | 1397 | 245 | 1397 |
| MNS 5919:2008 Уурын зуухны стандарт | 1050 | 1630 | 1030 | 12000 |

❖ Тайлбар: NOx- азотын ислүүд, $SO_2$ - хүхрийн давхар исэл, CO - нүүрстөрөгчийн дутуу исэл, TSP –нийт тоосонцор.

-Стандарт нийцсэн -Стандартаас давсан

БАТАЛСАН:
АГААРЫН ЧАНАРЫН ХЭМЖИЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЭРДЭНЭБАТ

ХЯНАСАН:
АГААРЫН ЧАНАРЫН ХЭМЖИЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ Б.НОМИН-ЭРДЭНЭ

ХЭМЖИЛТ ХИЙСЭН:
АГААР БОХИРДУУЛАГЧ СУУРИН ЭХ ҮҮСВЭРИЙН ХЭМЖИЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН У.ЖАРГАЛБААТАР



ХАСБАНК ЦАХИМ ГҮЙЛГЭЭНИЙ БАРИМТ

**ШИЛЖҮҮЛЭГЧИЙН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ**

| | |
|---|---|
| Банкны нэр: | ХасБанк |
| Данс: | 5002767309 |
| Нэр: | НЭЙШНЛ МАЙНИНГ МАШИНЕРИ ХХК |
| Дүн: | 142,880.00 |
| Валют: | MNT |

**ХҮЛЭЭН АВАГЧИЙН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ**

| | |
|---|---|
| Банкны нэр: | ХасБанк |
| Нэхэмжлэхийн №: | 3241200854476 |
| Нэр: | ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР |
| Дүн: | 142,880.00 |
| Валют: | MNT |

**ГҮЙЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ**

Гүйлгээний дугаар: **XB0080774**

Гүйлгээний утга: **3241200854476, Нэйшнл майнинг машинери, 88880024, НЭЙШНЛ МАЙНИНГ МАШИНЕРИ ХХК**

Гүйлгээний шимтгэл: **-**

Гүйлгээний хүсэлт илгээсэн: **nmm1** Гүйлгээ баталсан: **nmm3**

Гүйлгээ хийсэн огноо: **2024-12-10**

*Энэхүү цахим гүйлгээний баримтыг засварлах,Мэдээлэл өөрчлөх болон аливаа хууль бус зорилгоор ашиглахыг хориглоно.*

Ус бохирдуулсаны төлбөр төлсөн байдал



ХАСБАНК ЦАХИМ ГҮЙЛГЭЭНИЙ БАРИМТ

**ШИЛЖҮҮЛЭГЧИЙН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ**

| | |
|---|---|
| Банкны нэр: | ХасБанк |
| Данс: | 5002767309 |
| Нэр: | НЭЙШНЛ МАЙНИНГ МАШИНЕРИ ХХК |
| Дүн: | 175,772.80 |
| Валют: | MNT |

**ХҮЛЭЭН АВАГЧИЙН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ**

| | |
|---|---|
| Банкны нэр: | ХасБанк |
| Нэхэмжлэхийн №: | 1250106210321 |
| Нэр: | ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР |
| Дүн: | 175,772.80 |
| Валют: | MNT |

**ГҮЙЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ**

Гүйлгээний дугаар: **XB0213050**

Гүйлгээний утга: **1250106210321, Нэйшнл майнинг машинери, 88880024, НЭЙШНЛ МАЙНИНГ МАШИНЕРИ ХХК**

Гүйлгээний шимтгэл: **-**

Гүйлгээний хүсэлт илгээсэн: **nmm1** Гүйлгээ баталсан: **nmm3**

Гүйлгээ хийсэн огноо: **2025-01-10**

*Энэхүү цахим гүйлгээний баримтыг засварлах,Мэдээлэл өөрчлөх болон аливаа хууль бус зорилгоор ашиглахыг хориглоно.*

Усны нөөц ашигласан төлбөр төлсөн байдал

Төслийн үйл ажиллагаанаас гарч байгаа бохир усыг 2025 оны 7 дугаар сард мониторингийн хэмжилт дээжлэлтийн ажлыг стандарт, хэмжил зүйн газрын Нийслэлийн салбар Налайх дүүрэг дэх лабораторид шинжлүүлсэн. 2025 оны 08 дугаар сарын 08-ны өдөр Налайх дүүргийн менежерээс хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл авсан.





5/27/25, 4:15 PM GASI-LIMS

MNAS Accreditation system TL 205/01 MNS ISO/IEC 17025

Хүнсний Аюулгүй Байдлын Үндэсний Лавлагаа Лабораторийн ерөнхий захирлын 2023 оны 01 сарын 02-ны өдрийн А/02 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт Маягт 00-59

**СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН НИЙСЛЭЛИЙН САЛБАР НАЛАЙХ ДҮҮРЭГ ДЭХ ЛАБОРАТОРИ**

Улаанбаатар хот, Налайх дүүрэг, Дамдины гудамж

Утас: 70233301

**ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН**

***CERTIFICATE OF ANALYSIS***

**Бүртгэлийн дугаар** /Registration number/ : 25-119

**Шинжилгээ хийлгэх хүсэлт гаргасан газрын нэр :** Нэйшнл майнинг машинэри ХХК /The name of customer's request for analysis/

**Дэд лабораторийн нэр** /Name of the sub laboratory/ : Нян судлалын хяналтын лаборатори; Хими, хор судлалын хяналтын лаборатори

| Дээжийн тодорхойлолт | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Дээжийн дугаар | Дээжийн нэр | Цувралын дугаар | Үйлдвэрлэсэн улс | Бүтээгдэхүүний хүчинтэй хугацаа | Дээжийн тоо хэмжээ |
| 323 | Бохир ус | | Монгол Улс | Тодорхойгүй | 2.0 л |

| Хүлээн авсан огноо | Шинжилгээ дууссан огноо | Хэвлэсэн огноо |
|---|---|---|
| 2025 он 05 сар 19 өдөр | 2025 он 05 сар 26 өдөр | 2025 он 05 сар 27 өдөр |

| Дээжийн дугаар | Шинжилгээний аргын стандарт | Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж | Шаардлага | Шинжилгээний дүн |
|---|---|---|---|---|
| 323 | MNS 5668:2006 | *ББЕТ* | - | 1,3*10^6 |
| | MNS 5668:2006 | Эмгэгтөрөгч нян | <1; илрэхгүй | <1; илрээгүй |
| | MNS 5668:2006 | Гэдэсний бүлгийн савханцарын таньц | - | 0.0004 |
| | MNS 5668:2006 | Clostridium perfringens | - | 0.000001 |
| | MNS ISO 5815-1:2015 | Биохимийн хэрэглээт хүчилтөрөгч | <20,0, мгО/л | 68,0 |
| | MNS ISO 7890-3:2001 | Нитрат | -, мг/л | 1,1 |
| | MNS ISO 10523:2001 | pH | 6-9 | 7,06 |
| | MNS 6271:2011 | Сульфат | -, мг/л | 52,6 |
| | MNS ISO 11923:2001 | Умбуур бодис | <30, мг/л | 26,0 |
| | MNS 4424:2005 | Хлорид | -, мг/л | 226,8 |
| | MNS ISO 6777:2001 | Нитрит | -, мг/л | 0,29 |
| | MNS ISO 6878:2011 | Фосфат | -, мг/л | 0,46 |
| | MNS ISO 5813:1999 | Уусан хүчилтөрөгчийн агуулга | -, мг/л | 6,08 |

**Санал тайлбар:** /Opinions and interpretation/

**БАТАЛСАН:** ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ: /Approved by/ /Х .АЛТАНЧИМЭГ/

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ TL

Энэ шинжилгээний дүн нь зөвхөн шинжилгээ хийсэн дээжинд хамаарна. Шинжилгээний дүнг лабораторийн зөвшөөрөлгүй хуулбарлахыг хориглоно.

https://gasi.shinjilgee.mn/generalTestPage?sid=0# 1/1

Хаягдал усны дээж шинжилгээнд хамруулсан байдал



## ХАЯГДАЛ УСНЫ ДҮГНЭЛТ

2024 оны 11 дугаар сарын 20 -ний өдөр | Дугаар E-2411-000022 | Улаанбаатар хот Утас: 265528, 265578

### Нэг. Ерөнхий мэдээлэл

**1.1. Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар:**

| | |
|---|---|
| Оноосон нэр: | Нэйшнл майнинг машинери |
| Улсын бүртгэлийн дугаар: | |
| Регистрийн дугаар: | 6268919 |
| Захирал: | Хишигбат |
| Холбоо барих дугаар:: | 75003377 |

**1.2. Төслийн нэр, байршил:**

| | |
|---|---|
| Төслийн нэр: | Нэйшнл Майнинг Машинери ХХК |
| Байршил: | Улаанбаатар, Налайх, 3-р хороо |
| Дэлгэрэнгүй хаяг: | Улаанбаатар, Налайх, 3-р хороо, 504/01 тоот |
| Харьяалагдах сав газар: | Туул голын сав газар |

### Хоёр. Хаягдал усны талаарх мэдээлэл

**2.1. Хаягдал ус хаях цэгийн байршил, цэвэрлэгээний арга, түвшин**

| | |
|---|---|
| Хаягдал ус нийлүүлэх хэлбэр: | Төвлөрсөн системд |
| Нийлүүлж буй хаягдал усны төрөл: | Унд ахуй |
| Нэмэлт тайлбар: | Тус компанийн унд ахуйн хаягдал усны хэрэглээнээс гарсан хаягдал усыг 10 м3 багтаамжтай зориулалтын бетондсон цооногт шингэн хаягдлыг цуглуулж, Налайх дүүргийн ОНӨААТҮГ-тай хийсэн гэрээний дагуу зайлуулдаг. |

**2.2. Хаягдал усны хэмжээ**

| Хаягдал ус нийлүүлэх байгууламж | Хүчин чадал | Хаягдал усны төрөл | Хаягдал ус хаях зайлуулах цэг | Нийлүүлэлт | Цэвэрлэгээний арга | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| Унд ахуйн хаягдал ус | 16 | [Унд ахуйн хаягдал ус] | Ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд | | Механик, биологи | Хаягдал усны хэмжээ: 1 ажилтан албан хаагч өдөрт 150 л ус хэрэглэнэ гэж үзвэл: 16 ажилтан албан хаагч 300 хоног ажиллахад 300 хон x 16 хүн x150 л = 720.0 м3; |

Хаягдал усны дүгнэлт



Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,
Барилга, хот байгуулалтын сайдын
2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн
А/719/189 дүгээр тушаалын хавсралт

## ХАЯГДАЛ УС ХАЯХ, ЗАЙЛУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар: 25/03

Туул голын сав газрын захиргаа -ын гаргасан
/ Дүгнэлт гаргасан байгууллага /
20 24 оны 11 дугаар сарын 20 -ны өдрийн хаягдал ус хаях, зайлуулах E-2411-000022 тоот дүгнэлтийг үндэслэн Улаанбаатар аймаг/нийслэл Налайх сум/дүүргийн 3 дугаар хороо байршилтай
/ хаяг /
Уул уурхайн тоног төхөөрөмж, сэлбэг үйлдвэрлэл
/ үйл ажиллагааны чиглэл /
чиглэлээр хаягдал ус гаргаж байгаа "Нэйшнл майнинг машинери" ХХК -д
/ хүн, хуулийн этгээдийн нэр /
Улаанбаатар аймаг/нийслэл, Налайх сум/дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байршилтай хаягдал ус зайлуулах цэг буюу хүрээлэн буй орчинд болон төвлөрсөн бохир усны шугамд жилд 1.47 мян.м³ хаягдал усыг "Хүрээлэн байгаа орчин, Усны чанар, хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 4943:2015", "Хүрээлэн байгаа орчин, усны чанар, Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 6561:2015" стандартаар тогтоосон норматив шаардлагад нийцүүлэн хаях, зайлуулах зөвшөөрлийг
/ аль нь болохыг доогуур нь зурах /
нэг жилийн хугацаагаар олгож, ус бохирдуулсны төлбөрийн гэрээ болон дүгнэлтийг зөрчөөгүй тохиолдолд зөвшөөрлийг жил бүр сунгагдсанд тооцно. Хаягдал усны хэмжээ болон хаягдал ус зайлуулах цэг, төвлөрсөн бохир усны шугамын байршил өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр шинээр зөвшөөрөл олгоно.

Зөвшөөрлийн бичиг олгосон:

Налайх дүүргийн менежер | | С.Ялалт
/ Зөвшөөрөл олгосон байгууллага / | / Гарын үсэг / | / Гарын үсгийн тайлал /

Тамга

20 25 оны 08 -р сарын 06 -ны өдөр

Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл

- Хөрс, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээний хүрээнд 3 ажил төлөвлөж хэрэгжүүлсэн.

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хөрсний бохирдол | Барилга байгууламжийн гадна талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчныг цэвэр байлгах | Төслийн талбай | Жилдээ | • Төсөл хэрэгжүүлэгч 2000 м2 талбайд ногоон байгууламж байгуулсан, тайлант онд бүх нийтийг хамарсан цэвэрлэгээ болон ногоон байгууламжийг арчлах ажлыг удаа дараа зохион байгуулсан. Дэлгэрэнгүйг 2.3.1 дэх хэсгээс харна уу. |
| 2 | | Хөрсөн орчны мониторинг судалгааг хийх | Төслийн талбайн хөрс | Жилдээ | • 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдөр Хөрсний дээж авч “Нарт шуун” ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн. Дэлгэрэнгүйг 2.3.1 дэх хэсгээс харна уу. |
| 3 | | Төслийн хог хаягдлыг дүүргээс зөвшөөрөгдсөн цэгт хаяж зайлуулах | Төслийн талбайд | Жилдээ | • Налайх тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ хийсэн 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн “Хог хаягдлын төлбөрт үйлчилгээ үзүүлэх гэрээ”-тэй. Налайх дүүргийн татварын хэлтэстэй 2025 оны 02 сарын 04-ний өдрийн Хураамж төвлөрүүлэх гурвалсан гэрээтэй. Дэлгэрэнгүйг 2.3.1 дэх хэсгээс харна уу. |

### ➢ 2.3.1. Хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх

Төсөл хэрэгжүүлэгч 2000 м2 талбайд ногоон байгууламж байгуулсан. Төсөл хэрэгжүүлэгч нь орон нутгийн нөхөн сэргээлт хийх төлөвлөгөөнд тусгасан газруудад жилд хавар намартаа нийлээд 8 зүйлийн 167 ширхэг 16810000 төгрөгийн үнэ бүхий гоёлын модыг 2024 онд тарьж тайлант жил буюу 2025 онд эдгээрийг арчлах, услах ажилд төсөв зарцуулан ажилласан. Үйлдвэрийн бүсэд ногоон байгууламжийг хийж гүйцэтгэсэн нь нүүрсхүчлийн хий болон бусад хий, дуу чимээг шингээх өндөр ач холбогдолтой сайн ажил болсон.





Ногоон байгууламжийн батлагдсан төлөвлөгөөний дагуу мод тарьж буй байдал









Тайлант онд ногоон байгууламжийг арчилж буй байдал






Орчны цэвэрлэгээ буюу бүх нийтийн цэвэрлэгээ хийж буй байдал

**Судалгаа хийсэн талбайн тарималжуулсан мод**

Хүснэгт 51.Судалгаа хийсэн талбайн тарималжуулсан модны зүйлийн жагсаалт

| № | ***Зүйлийн Латин нэр*** | **Зүйлийн Монгол нэр** | **т/ш** | **Үнэ/өртөг** | **Нийт дүн төг** |
|---|---|---|---|---|---|
| 1 | *Сибирь хөх гацуур* | | 32 | 450000 | 14400000 |
| | *Буйлс* | | 20 | 3500 | 700000 |
| 2 | *Caragana arborescens* | шар Хуайс | 10 | 5500 | 550000 |
| 3 | *Ulmus pumila L.* | одой Хайлаас | 40 | 4500 | 180000 |
| 4 | *Populus tremula L.* | улиангар Улиас | 20 | 2500 | 50000 |
| 5 | *Hippophae zhamnoirdes* | яшилдуу Чацаргана | 2 | 5000 | 10000 |
| 6 | *Berberis vulgaris* | Энгэл тошлой | 20 | 8000 | 160000 |
| 7 | *Syringa vulgaris* | Энгэл голтбор | 3 | 20000 | 60000 |
| 8 | *Сарнайн бут* | | 22 | 3500 | 700000 |
| **Нийт дүн** | | | 169 | - | **16810000** |

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт тусгасны дагуу тогтоосон цэгүүдээс хөрсний сорьц дээж авч 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдөр Хөрсний дээж авч "Нарт шуун" ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн.



"НАРТ ШУУН КОНСАЛТИНГ" ХХК
ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан дүүрэг, 19-р хороо, УЭГ, ЗК 17024 Ш/х 10
Утас: (976)-99176123, 99231836
E-mail: nartconsulting@gmail.com

№ 25/10-09/1

Захиалагч: **"Нэйшнл майнинг машинери" ХХК**
Дээж авсан цэг: **НД 3 хороо**
Сорьц авсан огноо: **2025 оны 10 сар 02 өдөр**
Шинжилгээ хийсэн огноо: **10 сарын 09**

1. ХӨРСНИЙ ХИМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| № | Дээжний дугаар | pH | Давс, % | ЦДЧ, ds/m | Ялзмаг, % | $CaCO_3$, % | $NO_3$, мг/100г | Солилцох сууриуд, мг-экв/100 г | | Шим тэжээлийн элементүүд, мг/100г | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | $Ca^{+2}$ | $Mg^{+2}$ | $P_20_5$ | $K_20$ |
| 1 | Дотор тал | 7.81 | 0.032 | 0.075 | 2.56 | 0.64 | 0.25 | 19 | 5 | 1.7 | 27 |
| 2 | Гадна тал | 7.74 | 0.022 | 0.052 | 2.23 | 0.00 | 0.15 | 22 | 6 | 1.8 | 18 |

2. ХӨРСНИЙ МЕХАНИК БҮРЭЛДЭХҮҮН

| № | Дээжний дугаар | Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| 1 | Дотор тал | 0.0 | 49.0 | 24.9 | 13.5 | 4.8 | 7.8 | 26.1 |
| 2 | Гадна тал | 0.4 | 53.3 | 21.6 | 10.7 | 4.6 | 9.4 | 24.7 |

3. ХӨРСНИЙ ЭРҮҮЛ АХУЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН. 1ГР ХӨРСӨНД

| № | Дээжний дугаар | Нянгийн тоо | Гэдэсний савханцрын титр (*E.coli*) MNS 3297:2019 | | *Анаэробын (Cl.perfringens* MNS 3297:2019 | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Шинжилгээний хариу | Шинжилгээний хариу | Бохирдлын зэрэг | Шинжилгээний хариу | Бохирдлын зэрэг |
| 1 | Дотор тал | $6.9*10^5$ | ≥0.1 | 1 | ≥0.1 | 1 |
| 2 | Гадна тал | $3.5*10^5$ | ≥0.1 | 1 | ≥0.1 | 1 |

4. ХӨРСНИЙ ХҮНД МЕТАЛЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| Дээж авсан газар, Газар зүйн байршил | Дээж авсан гүн, см | Cr | Pb | Cd | Zn | Cu | Ni |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | мг/кг | мг/кг | мг/кг | мг/кг | мг/кг | мг/кг |
| Дотор тал | 0-30 | 50.0 | 9.4 | 0.0 | 42.9 | 3.4 | 19.2 |
| Гадна тал | 0-30 | 10.0 | 9.4 | 0.0 | 10.4 | 4.6 | 7.4 |
| Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019 | | | | | | | |
| Элсэрхэг хөрс | | 60 | 50 | 1 | 100 | 60 | 60 |
| Шавранцар хөрс | | 100 | 70 | 1.5 | 150 | 80 | 100 |
| Шаварлаг хөрс | | 150 | 100 | 3 | 300 | 100 | 150 |

**Хяналтын түвшин* ** Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарна*

*ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТУУД : (Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд* MNS3310:1991, MNS ISO10390, *хөрсний механик бүрэлдэхүүн* MNS6824:2020, *Эрүүл Ахуйн Шинжилгээний Стандарт* MNS 5367:2004, MNS6341:2012,*Хүнд металлуудыг -хаан дарсанд атом шингээлтийн спектрометрээр* MNS ISO 11466:2007*)*

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭСЭН: Х.УУГАНЦЭЦЭГ, С.НЯМДАШ
ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ Т.СОЛОНГО Ph.D, Дэд профессор

2025 ОНЫ 10 САРЫН 10 2




НАРТ ШУУН консалтинг ХХК-ийн хөрсний итгэмжлэгдсэн лабораторт шинжлүүлсэн

Налайх тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ болон Налайх дүүргийн татварын хэлтэстэй 2025 оны 02 сарын 04-ний өдрийн Хураамж төвлөрүүлэх гурвалсан гэрээ байгуулан ажиллаж байгаад гэрээний дунд үнийн өөрчлөл орсон гэх үндэслэлээр Налайх тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ -тай 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн "Хог хаягдлын төлбөрт үйлчилгээ үзүүлэх гэрээ" байгуулан ажиллаж байна.



БАТЛАВ. ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГА Ц. АЛТАНЦООЖ

БАТЛАВ. "ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ" ОНӨААТҮГ-ЫН ДАРГА Ц.ЭРБОЛ

БАТЛАВ.

ХУРААМЖ ТӨВЛӨРҮҮЛЭХ ГЭРЭЭ

2025 оны 02 сарын 04 өдөр №17 Налайх дүүрэг

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах, ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх харилцааг зохицуулах, аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгч нэг бүрийн үүрэг хариуцлагыг тодорхойлж дүгнэх, Нийслэлийн ИТХ-ийн Тэргүүлэгчдийн 2009 оны 63-р тогтоолоор батлагдсан "Хот тохижилт, цэвэрлэгээний талаар албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дагаж мөрдөх журам","Журамд өөрчлөлт оруулах тухай" Налайх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн "Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэм хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоолыг хэрэгжүүлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

Энэхүү гэрээг нэг талаас Татварын хэлтэс, Налайх Тохижилт Үйлчилгээ ОНӨААТҮГ-ыг төлөөлж ...., аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчийг төлөөлж .... хаягтай, 6268919 регистрийн дугаартай .... /ХХК, иргэн/ бид харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

НЭГ: "ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ" ОНӨААТҮГ-ЫН ЭРХ, ҮҮРЭГ

1.1 Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн хог хаягдлыг тээвэрлэхдээ хог хаягдлын хураамжийг төсөвт төлсний дараа сард нэг удаа өөрийн тээврийн хэрэгслээрээ тээвэрлэнэ.
1.2 Татварын хэлтэстэй хамтран хог хаягдлын гэрээг аж ахуйн нэгж, иргэдтэй жил бүр байгуулна.
1.3 Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хог тээврийн үйлчилгээг батлагдсан хуваарийн дагуу бүрэн хариуцаж тээвэрлэнэ.
1.4 Хог тээвэрлэлтийн талаарх санал гомдлыг хүлээн авч тухай бүр нь шуурхай шийдвэрлэнэ.
1.5 Тээвэрлэгч байгууллага нь Татварын хэлтэстэй тооцоо нийлсний үндсэн дээр хог хаягдлын хураамжаа 3 сараас дээш төлөөгүй аж ахуйн нэгж, иргэдийн хогийг тээвэрлэхгүй.

ХОЁР. ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ЭРХ, ҮҮРЭГ

2.1 Татварын хууль тогтоомжийн дагуу сар бүрийн 25-ны өдрийн дотор гэрээнд заасан үйлчилгээний хураамжийн дүнгээр хураан төвлөрүүлнэ.
2.2 Аж ахуй нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн авлага, өглөгийн мэдээг сар бүр гаргаж Налайх Тохижилт Үйлчилгээ ОНӨААТҮГ-т хүргүүлэн тооцоо нийлнэ.
2.3 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах эрхийг цуцлуулах хүртэлх саналыг холбогдох байгууллагууд хүргүүлнэ.

Хураамж төвлөрүүлэх гурвалсан гэрээ



БАТЛАВ: НАЛАЙХ "ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ" ОНӨААТҮГ-ЫН ДАРГА Ц.ЭРБОЛ

ХОГ ХАЯГДЛЫН ТӨЛБӨРТ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

20(25) оны (09) сарын (22)-ны өдөр № Налайх дүүрэг

| | |
|---|---|
| Иргэн, ААНБ-ын нэр | "Нэйшнл Майнинг Машинери" ХХК |
| Регистрийн дугаар | 6268919 |
| Үйл ажиллагаа явуулж буй объектын оноосон нэр: | |
| Үйл ажиллагааны чиглэл | |
| Иргэн, ААНБ-ын хаяг | 3-р хороо 504-тоот |
| ААНБ-ын холбогдох утас | 99291708 |
| Газар зүйн хязгаарлалт | Налайх дүүргийн 3 хороо |
| Данс:5749062084 | Хаан банк |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төрөл | |
| Төлбөрийн нөхцөл | |
| Гэрээний хугацаа | 2025-9-22 – 2026-9-22 |

Энэхүү гэрээ нь Монгол Улсын хог хаягдлын тухай (шинэчилсэн найруулга) хууль, Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах, ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх харилцааг зохицуулах, аж ахуйн нэгж байгууллага, ХХЭрхлэгч нэг бүрийн үүрэг хариуцлагыг тодорхойлж дүгнэх, Эрүүл ахуйн тухай хууль, Нийслэлийн ИТХ-ийнТэргүүлэгчдийн 2009 оны 63-р тогтоолоор батлагдсан "Хот тохижилт,цэвэрлэгээний талаар албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дагаж мөрдөх журам","Журамд өөрчлөлт оруулах тухай" Нийслэлийн ИТХ-ийн 2012 оны **61**-р тогтоол, Налайх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 19/04 дугаар тогтоол болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн баримтална.

Нэг талаас Налайх дүүргийн Тохижилт Үйлчилгээ ОНӨААТҮГ /цаашид "хог хаягдал тээвэрлэгч" гэх/ нөгөө талаас /.................................................../
/иргэн, аж ахуй нэгж байгууллагын нэр/

Төлөөлж /цаашид "Хог хаягдал "тээвэрлүүлэгч" гэх .................... ажилтай .................... овогтой .................... нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Энэхүү гэрээ нь Налайх дүүргийн ...3...-р хорооны нийтийн эзэмшлийн зам талбай, айл өрх, аж ахуй нэгж байгууллагын хог хаягдлыг цуглуулж, ачиж тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хүргэж хариуцсан бүсийг хог хаягдалгүй цэвэр байлгахад оршино.

Хог хаягдлын төлбөрт үйлчилгээ үзүүлэх гэрээ

- Биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээний хүрээнд 6 ажил төлөвлөж хэрэгжүүлсэн.

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ургамал | Үйлдвэрийн хашаан доторх сул чөлөөт талбайг тарималжуулж нөхөн сэргээх | Төслийн талбай | Жилдээ | • Төсөл хэрэгжүүлэгч 2000 м2 талбайд ногоон байгууламж байгуулсан. Мод тарьсан хэсгээс бусад хэсгийг зүлэгжүүлсэн. Дэлгэрэнгүйг 2.4.1 дэх хэсгээс харна уу. |
| 2 | | Төслийн үйл ажиллагааг илэрхийлсэн нэр хаяг бүхий самбар, ногоон байгууламж, явган хүний зам, талбай, тээврийн зогсоол зэргийг тэмдэгжүүлэх | Төслийн талбай | Жилдээ | • Төслийн үйл ажиллагааны талаар 9х4 метрийн хэмжээтэй самбарыг төв замруу харуулан байршуулж, явган хүний зам, зогсоол зэргийг тэмдэгжүүлсэн. Дэлгэрэнгүйг 2.4.1 дэх хэсгээс харна уу. |
| 3 | Амьтан | Цахилгаан дамжуулах шугамын шувуунд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор шувуу үргээгч байршуулах талаар судлах | Төслийн талбайн цахилгааны шугам | Жилдээ | • Улаанбаатар хотын Цахилгаан Түгээх” ХК-тай “Цахилгаан эрчим хүчээр хангах” гэрээний дагуу үйлдвэрийн цахилгааны хэрэглээгээ шийдвэрлэдэг. Үйлдвэрийн хажуу талын цахилгааны шон хазгай буюу хазаалттай байгаа учир 2026 онд цахилгааны шонг засахаар төлөвлөсөн бөгөөд энэ үеээр шувуу үргээгч суурьлуулахаар төлөвлөөд байна. |
| 4 | | Сэргээгдэх эрчим хүчийг илүүтэй сонгож хэрэглэх | Төслийн талбай | Жилдээ | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | Цахилгаан эрчим хүчний хэрэглээ | Цахилгаан эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжийг сонгож хэрэглэх | Төслийн талбай | Жилдээ | • Төслийн технологийн дамжлага бүрд эрчим хүчийг ашиглах юм. Үйлдвэрийн цахилгаан эрчим хүчний гол хэрэглэгчид нь бигнүүрийн машин, бигнүүрийн зуух, гүүрэн кран, ус татах насос, засварын газрын тоног төхөөрөмжүүд, уурын зуух, барилга, байгууламжуудын гэрэлтүүлэг, гүний худаг, компрессор зэрэг байдаг. Тиймээс цаашид сэргээгдэх эрчим хүчийг илүүтэй ашиглах судалгааны ажил хийхээр төлөвлөж байна. |
| 6 | | Ариун цэврийн газар нь агааржуулагч сэнстэй болгох | Ариун цэврийн өрөө | Жилдээ | • Ариун цэврийн газрыг салгаж, залгадаг агааржуулалтын сэнстэй болгосон. |

- **2.4.1. Ургамлын төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх**

Хээрийн судалгаагаар төслийн талбай орчим уулын хар хүрэн хөрстэй нугархаг хээрийн Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц 54%, зүйлийн бүрэлдэхүүн харьцангуй цөөн, 1м2 талбайд 22 зүйл ургамал тархаж, ойролцоогоор 4ц/га ургацтай. Ургамлын дундаж өндөр 20 25см.Ургамлын амьдралын хэлбэрээр нь эзлэж байгаа хувиар сөөг 3%, сөөгөнцөрлөг 3%, олон наст өвс 52%, ганц ба хоёр наст 42% байна.Судалгааны талбайд 1 ховор ургамал бүртгэгдсэн. Төслөөс ургамлан нөмрөгт үзүүлэх 2 нөлөөлөл байгаагийн 100.0 хувь бага эрчимтэй байна. Ургамалд үзүүлэх сөрөг нөлөө нь тодорхой зүйл ургамал устаж үгүй болох хүртэл сүйрлийн түвшний сөрөг нөлөө үзүүлэхгүй. Мөн төслийн 2000 м2 талбайд ногоон байгууламж байгуулсан.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд өртөж эвдэрсэн хөрсөн бүрхэвчийг засаж тэгшлэх, олон наст ургамлын үр тарих (зүлэг), мод, сөөг тарих зэргээр ургамалжуулах, ногоон байгууламж байгуулан ажиллаж байна.

| | |
|---|---|
|  |  |
| Зүлэгжүүлэхээс өмнө | Зүлэгжүүлсэний дараа |

Резинэн бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн үйлдвэр нь Налайх дүүргийн 3-р хорооны нутагт Налайхын төвөөс шулуунаар баруун урд зүг буюу 2400-т 2.3 км зайд

Улаанбаатар-Чойрын чиглэлийн төв автозамаас баруун зүгт 50 м зайд хээрийн бүс нутагт байрладаг. Тайлант онд 9х4 метрийн хэмжээтэй танилцуулга самбарыг байршуулсан.




Байршуулсан самбар




Самбар байршуулсан байдал

➢ **2.5.1. Амьтны төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх**

Төсөл хэрэгжүүлэгч нь “Улаанбаатар хотын Цахилгаан Түгээх” ХК-тай “Цахилгаан эрчим хүчээр хангах” гэрээний дагуу үйлдвэрийн цахилгааны хэрэглээгээ шийдвэрлэдэг. Үйлдвэрийн цахилгаан эрчим хүчний гол хэрэглэгчид нь бигнүүрийн машин, бигнүүрийн зуух, гүүрэн кран, ус татах насос, засварын газрын тоног төхөөрөмжүүд, уурын зуух, барилга, байгууламжуудын гэрэлтүүлэг, гүний худаг, компрессор, тэслэгч машин зэрэг болно. Үйлдвэр, туслах үйлдвэрлэл болон ахуйн хэрэглээг цахилгаан эрчим хүчээр хангахын тулд 1 км орчим газар өндөр хүчдэлийн шугам татаж 6/0.4 кВ-ийн дэд станцаар тавьж цахилгаанаар хангадаг. Үйлдвэрийн хажуу талын цахилгааны шон хазгай буюу хазаалттай байгаа учир 2026 онд цахилгааны шонг засахаар төлөвлөсөн бөгөөд энэ үеэр шувуу үргээгч суурьлуулахаар төлөвлөөд байна.



Цахилгааны шон



Суурьлуулах шувуу үргээгч

## 3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тайлант онд үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөгөөр 4 ажил төлөвлөн хэрэгжүүлсэн.

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ногоон байгууламж бий болгох | Шинэс, нарс /сонгож болох/ болон бусад мод тарих | Төслийн талбайн хэмжээнд | Жилдээ | • Төсөл хэрэгжүүлэгч нь орон нутгийн нөхөн сэргээлт хийх төлөвлөгөөнд тусгасан газруудад жилд хавар намартаа нийлээд 8 зүйлийн 167 ширхэг 16810000 төгрөгийн үнэ бүхий гоёлын модыг тарьсан. |
| 2 | | Буйлс /сонгож болох/ тарих | | Жилдээ | |
| 3 | | Зүлэгжүүлэх | | Жилдээ | |
| 4 | Зүлэгжүүлэлт, цэцэрлэгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэх | /Хар шороо, элс, бууц зэргийг бэлтгэнэ/ | Ажилчны хөлс | Жилдээ | • Төслийн нийт талбайн 20 хувиас багагүй талбайд ногоон байгууламж байгуулах зорилгоор төслийн 19884 м/кв талбайд ногоон байгууламж 2000 м/кв талбайг ногоон байгууламж буюу зүлэгжүүлэх, цэцэрлэгжүүлэлт хийгээд байна. |
| 5 | Дуслын усалгааны систем | Усалгаа | Төслийн талбайд | Жилдээ | • Ногоон байгуулжийн усалгаанд 240 м3/жил нийт 12.15 м3/хон ус ашиглана гэж тооцон дуслын усалгааны системийг ашиглан усалгааг хийж байна. |
| 6 | Тоног төхөөрөмж | Ногоон байгууламжид шаардлагатай багаж тоног төхөөрөмж | Төслийн талбайд | Жилдээ | • Ногоон байгууламжийн усалгаа, арчилгаанд шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг худалдан авч, цэцэрлэгжүүлэлтийн ажилд ашиглаж байна. |

### ➢ 3.1.1. Орчны тохижилт, цэцэрлэжүүлэлтийн чиглэлээр

Төслийн 19884 м/кв талбайд үйлдвэрийн барилга 4455 м/кв, бэлэн бүтээгдэхүүний агуулах 2550 м/кв, конторийн зориулалттай 2 давхар барилга 1600 м/кв, ногоон байгууламж 2000 м/кв, цементэлсэн талбай 2400 м/кв, харуулын байр 20 м/кв, ногоон байгууламж 2000 м/кв, цементэлсэн сул газар болон бусад 9379 м/кв талбайг хамаарч байна. Үйлдвэр байрлах газар нь Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Монгол Дагуурын уулын ойт хээрийн тойрог, хуурай хээрийн экосистемд байрлах ба 2000 м2 талбайд ногоон байгууламж хийсэн. Ногоон байгууламж нь ариун цэвэр, гоо сайхны үнэлж баршгүй ач холбогдолтой бөгөөд агаарын бохирдол, таагүй нөхцөлийг бууруулж хүний тохь тухтай, эрүүл амьдрах орчныг бүрдүүлдэг байна. Мод сөөг нь орчны агаарыг тоос шороонoос цэвэрлэх байгалийн шүүлтүүр болдог. Агаарын бохирдлоос хамгаалах, тоосыг өөртөө шингээх чадамж нь зуны улиралд 30%, өвөл 37% болохыг судлаачид тогтоожээ. Зөвхөн нэг ширхэг хайлаас ургалтын хугацаандаа 28 кг тоос шороог өөртөө шингээдэг бол нэг га талбайн ой мод цагт 200 хүний амьсгалаар гарсан нүүрсхүчлийн хийг шингээж, 2500 тн ус ууршуулж агаарыг чийглэг зөөлөн болгодог байна.







| Ногоон байгууламж төлөвлөсөн байдал | Ногоон байгуулжамж гүйцэтгэсэн байдал |
|---|---|



Дуслын усалгааны систем

Ногоон байгууламж, тохижилтын асуудлыг шийдэхээр дараах багаж болон санхүүгийн асуудлыг шийдвэрлэсэн.

| д/д | Төхөөрөм-жийн нэр, зориулалт | Хэмжих нэгж | Бүтээмж | Үйлдвэр-лэсэн улс | Үнэ, төг | Зүтгэх хүчний машин чадал | Зураг |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Bilateral handle Гар үрлэгч, таригч | Хүн/га | 0,5 | БНХАУ | 250.000 | - |  |
| 2 | Мод шилжүүлэн суулгагч | Цаг/ш | 20 | Монгол | 300.000 | - |  |
| 3 | Мөчрийн хайч | - | - | БНХАУ | 80.000 | 980гр |  |
| 4 | Сийрүүлүүр /хог ургамал, зэрлэг устгах/ | га/цаг | 0.6 | Монгол | 1.200.000 | 18-25 м.х |  |
| 5 | Өвөөлжин царил | | | | 220.000 | |  |
| 6 | Хүрз | | | Орос | 30.000 | |  |

## 4. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|
